

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ БУСАД ТӨРИЙН ТУСГАЙ АЛБА ХААГЧИЙН БАТАЛГААТАЙ ХАРЬЦУУЛАН СУДЛАХ НЬ

Б.Пүрэвсүрэн

ДХИС-ийн Удирдлагын академийн 8021 дүгээр дамжааны суралцагч,
цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Энэхүү өгүүллэгээр байгууллагын дэмжлэгийн онолд тулгуурлан цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг төрийн тусгай бусад алба хаагчийн нийгмийн баталгаатай харьцуулан судалж, дүн шинжилгээ хийсэн. Төрийн тусгай алба хаагчдын баталгааг салбарын хуулиудад олон янзаар нэрлэсэн байх бөгөөд цагдаагийн алба хаагч нь улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засгийн болон бусад баталгаагаар хангагдана гэж заасан. Тиймээс цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэхэд байгууллагын дэмжлэг маш чухал үүрэгтэй бөгөөд алба хаагчдыг дэмжсэнээр эерэг гүйцэтгэлтэй, үнэнчээр хариу үйлдэл үзүүлэх боломжууд нэмэгдэнэ.

Abstract: In this article, based on the theory of organizational support, the social security of a police officer is compared with the social security of other special government employees and analyzed. The guarantees of special public servants are named in many different ways in the laws of the sector, and it is stated that police officers are provided with political, legal, social, economic and other guarantees. Therefore, organizational support is very important for police officers to successfully carry out their duties of fighting crime, maintaining public order, and ensuring public safety, and supporting officers will increase opportunities for positive performance and loyal response.

Түлхүүр үгс. Цагдаагийн алба хаагч, нийгмийн баталгаа, байгууллагын дэмжлэгийн онол, ажлын гүйцэтгэл

Keywords: Police officers, social guarantees, organizational support theory, and job performance.

Оршил

Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэхэд шууд нөлөөлж, ажлын гүйцэтгэлд эерэг нөлөөлөх боломжтой байдаг. Гэсэн

хэдий ч нийгэм, эдийн засгийн хурдацтай өөрчлөлт, шинэчлэлтийн энэ цаг үед цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг хэрэгжүүлэх бодлого, чиглэл тодорхой хэмжээгээр шинэчлэгдэж байгаа хэдий ч алба хаагчдад хэрхэн нөлөөлж байгааг судалж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, сайжруулах арга замыг

эрэлхийлэх хэрэгцээ шаардлага өнөөдрийг хүртэл байсаар байна. Иймээс энэхүү сэдвийг дараах үндэслэлээр судаллаа. Үүнд:

1. ЦЕГ-аас цагдаа, дотоодын цэргийн 46 нэгж байгууллагын 2771 алба хаагч, ажилтнаас авсан судалгаагаар “алба хаагчийн орон тоо дутуу, ажлын ачаалал их” (1443 алба хаагч буюу 52.1% нь), “удирдах албан тушаалтны мэдлэг, харилцааны ур чадвар дутмаг, хэл амаар доромжлох, ялгаварлан харьцах, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэднээс гаргасан санал хүсэлтийг шийдвэрлэх чиглэлээр дорвитой ажил, арга хэмжээ зохион явуулдаггүй” гэж 21.5 хувь нь хариулсан нь цагдаагийн алба хаагч албандаа сэтгэл ханамжгүй байгаа нь харагдаж байна. Энэ нь цагдаагийн байгууллагын төсөв, санхүүгийн хүрэлцээгүй байдал, удирдлагын дотоод зохион байгуулалтын оновчгүй, алба хаагчдаа дэмждэггүй, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалдаггүй болох нь харагдаж байна.

2. Цагдаагийн албаны тухай хуульд заасан нийгмийн баталгаа нь ажил үүргээ хэвийн гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангаж, ажлын бүтээмжид шууд нөлөөлөх, нийгэмд тулгамдаж буй асуудалд бэлэн байх, даван туулах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн байх шаардлагатай. Гэтэл өнөөдрийн

нийгэмд хэрхэн нөлөөлж, хуулийн хэрэгжилт ямар байгааг судалж, дүн шинжилгээ хийх хэрэгцээ шаардлага байна.

Энэхүү өгүүлэлтийн зорилго нь байгууллагын дэмжлэгийн онолд тулгуурлан цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг төрийн тусгай бусад алба хаагчийн нийгмийн баталгаатай харьцуулан судалж, түүний хэрэгжилтийг тодорхойлж, тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийж, сайжруулах арга замыг эрэлхийлнэ.

Байгууллагын дэмжлэгийн онол, түүний төрөл, хэлбэрийн талаар судлагдсан байдал. Б.Лэкей, С. Кохен нарын “Нийгмийн дэмжлэгийн онол ба хэмжилт” сэдэвт бүтээл нь эрүүл мэнд, нийгмийн шинжлэх ухааны судлаачдад зориулан бичигдсэн бүтээл юм¹.

Р. Эйзенбергер, Ж. Каммингс, С. Армели нарын “Байгууллагын дэмжлэг, өөрийн үзэмжээр хандах хандлага, ажлын сэтгэл ханамж” сэдэвт судалгааны ажилд алба хаагчдад байгууллагаас үзүүлж буй дэмжлэг нь хэрхэн нөлөөлж байгаа талаар сэтгэл ханамжийн судалгаа хийсэн байна².

Мөн “Байгууллагын дэмжлэг”-ийн талаарх бүтээлийн тоймлон судалсан судалгааны ажилд байгууллагын дэмжлэгийн тухай ойлголт, төрлийг судлаачид хэрхэн тодорхойлж, төрлийг хэрхэн ангилсан талаар судалжээ³.

¹ Lakey, B. and S. Cohen, 2000. Social support theory and measurement (pp. 29-52). In Social Support Measurement and Intervention: A guide for Health and Social Scientists. (Eds. Cohen, Underwood and Gottlieb).

² Eisenberger, R., Cummings, J., Armeli, S., & Lynch, P. (1997). Perceived organizational support, discretionary treatment, and job

satisfaction. Journal of Applied Psychology, 81(5), 812-820. doi: 10.1037//0021-9010.82.5.812

³ Rhoades, L., & Eisenberger, R. (2002). Perceived organizational support: A review of literature. Journal of Applied Psychology, 87(4), 698-714. doi: 10.1.1.561.8147

Цагдаагийн алба хаагчийн баталгаа, нийгмийн баталгааны талаар хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, цагдаагийн хурандаа Ж.Долгорсүрэн “Монгол Улсын цагдаагийн эрх зүйн курс”¹ М.Батаев “Монгол Улсын цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал”², Д.Таванжин “Монгол Улсын цагдаагийн эрх зүй”³, Б.Чимид БНМАУ-ын “Захиргааны эрх зүй”⁴, З.Батсүх “Сэргийлэн хамгаалах алба”⁵, Р.Гүнсэн Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм”⁶, С.Бүдрагчаа БНМАУ-д “Нийгмийн хэв журмыг сахиулах систем, Цагдан сэргийлэх байгууллага, түүний захиргааны үйл ажиллагаа, Гэмт хэрэгтэй тэмцэх асуудал”⁷, Ж.Долгорсүрэн “БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын захиргааны үйл ажиллагаа. Альбом-схем”⁸ гэх зэрэг бүтээлүүдийг дурдаж болно. Үүнээс гадна Цагдаагийн алба хаагчийн баталгааны талаар дараах магистрын судалгааны ажил байна. Үүнд:

А.Баасанцэрэн “Цагдаагийн алба хаагчийн баталгаа, түүний эрх зүйн зохицуулалт”, Н.Лхагвасайхан “Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг хангах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох

зарим асуудал”, магистрын ажил, Я.Ундармаа “Цагдаагийн алба хаагчийн үүргээ биелүүлэх эрх зүйн хамгаалалтын асуудал”, магистрын ажил, Х.Энхбаясгалан “Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, уламжлал шинэчлэлийн зарим асуудал” зэрэг магистрын ажлуудыг дурдаж болно.

Нэг. Байгууллагын дэмжлэгийн онол ба цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг харьцуулан судлах нь.

Нийгмийн дэмжлэг нь хүний үйлдэл, сэтгэл хөдлөл, сэтгэлийн байдал, танин мэдэхүйн үр дүн, харилцааны мөн чанар, ойлголтыг тодорхойлох чухал хүчин зүйлүүдийн нэг юм⁹. Эдгээр ойлголтыг нийгмийн солилцооны онол, байгууллагын дэмжлэгийн онолоор тайлбарладаг.

Байгууллагын дэмжлэгийн онол¹⁰ (perceived organizational support) нь нийгмийн солилцооны онол дээр үндэслэж, ажил олгогч ба ажилчдын хоорондын харилцааг тайлбарлах, байгууллагын үйл ажиллагааг дүгнэхтэй холбоотой онол юм. Өөрөөр хэлбэл, байгууллага ажилтныхаа өмнө хүлээсэн үүрэг нь эцсийн дүндээ байгууллагын үйл

ажиллагаа, Гэмт хэрэгтэй тэмцэх асуудал. УБ., 1985 он.

⁸ Долгорсүрэн, Ж. "БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын захиргааны үйл ажиллагаа. Альбом - схем" УБ., 1990 он.

⁹ Lakey, B. and S. Cohen, 2000. Social support theory and measurement (pp. 29-52). In Social Support Measurement and Intervention: A guide for Health and Social Scientists. (Eds. Cohen, Underwood and Gottlieb).

¹⁰ Eisenberger, R., Cummings, J., Armeli, S., & Lynch, P. (1997). Perceived organizational support, discretionary treatment, and job satisfaction. *Journal of Applied Psychology*, 81(5), 812-820. doi: 10.1037//0021-9010.82.5.812

¹ Долгорсүрэн, Ж. Булган Д. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. УБ., 2014 он

² Батаев, М. “Монгол Улсын цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал” 2006 он.

³ Таванжин, Д. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. УБ., 2006 он.

⁴ Чимид, Б. БНМАУ-ын Захиргааны эрх зүй, УБ., 1965 он

⁵ Батсүх, З. Сэргийлэн хамгаалах алба. УБ., 1975. 40 дэх тал.

⁶ Гүнсэн, Р. Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм. УБ., 1984 он

⁷ Бүдрагчаа, С. БНМАУ-д Нийгмийн хэв журмыг сахиулах систем. Цагдан сэргийлэх байгууллага, түүний захиргааны үйл

ажиллагааны төлөөх ажилчдын хариуцлага болон илэрдэг.

Энэхүү онолыг Р. Ейзинбегер, Р. Хантингтон, С. Хатчисон, Д. Сова нар анх 1986 онд “Байгууллагын дэмжлэгийн онол” сэдэвт бүтээлээр танилцуулсан¹ бөгөөд менежмент, нийгмийн сэтгэл судлалын салбарт хэрэглэгдэж, 1990 оноос анхаарал татсан шинэлэг асуудал болж, маш хурдацтай хөгжиж байна. Ийнхүү Р. Ейзинбэргийн судалгаанд үндэслэн дараагийн эрдэмтэд хэмжилтийн цар хүрээг боловсруулах, байгууллагын дэмжлэгт нөлөөлж буй хүчин зүйлүүд, байгууллагаас дэмжлэг үзүүлэхэд нөлөөлж буй эерэг нөлөөллийг голчлон анхаарч судалсан байна.

Байгууллагын дэмжлэгийн онолын үндэс нь байгууллагаас алба хаагчдыг дэмжих тодорхой үйл явц байдаг.² Тухайлбал,

1) Байгууллагын дэмжлэгийн онол нь нийгмийн солилцооны онол дээр үндэслэсэн сайн дурын харилцааны үйлчлэлд суурилдаг. Энэ нь байгууллага болон ажилчдын хоорондын харилцаанд суурилах бөгөөд байгууллагаас ажилчинд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой ажлын бүтээмж нэмэгдэх, харин дэмжлэг үзүүлэхгүй байхад буурах боломжтой. Энд эерэг харилцааг ажилтан мэдрэх үед ажилтан байгууллагынхаа өмнө хүлээсэн үүргээ ухамсарлаж, ашигтай харилцааг хадгалахын тулд хариу үйлдэл үзүүлдэг. Тухайлбал, “ажил олгогчид ажилчдадаа анхаарал халамж тавихад” нийгмийн солилцооны харилцаа хөгжиж,

улмаар үр өгөөжтэй үр дагаврыг бий болгодог” гэж үздэг.

2) Байгууллага ажилчдаа халамжтай, хүндэтгэлтэй хандвал хувь хүний нийгэм-сэтгэл санааны хэрэгцээ хангагдана гэж үздэг.

3) Байгууллагын дэмжлэгийн үйл явц нь ажилтны гүйцэтгэлтэй шууд холбогдох бөгөөд удирдлагын зүгээс урамшуулал, шагналтай холбоотой гэж үздэг. Өөрөөр хэлбэл, ажилчид шаргуу хөдөлмөрөөрөө үнэлэгдэх болно гэдэгт итгэснээр ажлын бүтээмж дээшилнэ.

Байгууллагын дэмжлэг гэдэг нь байгууллага ажилтныхаа оруулсан хувь нэмрийг үнэлэх, тэдний сайн сайхан байдалд санаа тавьж буйг илэрхийлэх, ажилтан байгууллагын хоорондын нийгмийн солилцооны мөн чанарыг хэмждэг гол ойлголт юм.

Ихэнх ажилчид байгууллагынхаа дэмжлэгийг хүлээн зөвшөөрч, хүсдэг бөгөөд дэмжлэг сайтай байгууллагад ажилтай холбоотой олон эерэг зан үйл бий болж, ажилтан байгууллагын нэрийн өмнөөс эрсдэл хүлээх, бие даан ажиллах хүсэл эрмэлзэл, идэвх чармайлт нэмэгдэх, сэтгэл ханамж, гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд тусалдаг байна. Үүний эсрэгээр, байгууллагын дэмжлэг багатай ажилтнууд ажлын цагийг үр ашиггүй өнгөрүүлэх, үүрэг даалгаврын бүтээмж буурдаг байна.

Тиймээс цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэхэд байгууллагын дэмжлэг маш чухал үүрэгтэй бөгөөд алба хаагчдыг

¹ Eisenberger, R., Huntington, R., Hutchison, S., & Sowa, D. (1986). Perceived organizational support. *Journal of Applied Psychology*, 71(3), 500–507.

² Rhoades, L., & Eisenberger, R. (2002). Perceived organizational support: A review of literature. *Journal of Applied Psychology*, 87(4), 698–714. doi: 10.1.1.561.8147

дэмжсэнээр эерэг гүйцэтгэлтэй, үнэнчээр хариу үйлдэл үзүүлэх боломжууд нэмэгдэнэ. Харин байгууллагын удирдлагаас дэмжлэг авахгүй байх нь захиргаа тэднийг хүндэтгэдэггүй гэсэн шинжийг илэрхийлж, ажлын гүйцэтгэлд муугаар нөлөөлдөг байна.

Энэ зарчимд үндэслэн ажилчид байгууллагын урамшуулал, ажлын таатай нөхцөл, цалин, хангамж, албан тушаал ахих, ажлын байрны сайжруулалт зэргээс хамаарч ажлыг илүү үр дүнтэйгээр хэрэгжүүлдэг.

Байгууллагын дэмжлэгийн онол нь олон төрлөөр илэрч байдаг бөгөөд манай улсын цагдаагийн алба хаагчийн үүргээ гүйцэтгэх баталгаагаар илэрч байна.

Шинжлэх ухааны доктор Ж.Долгорсүрэн “цагдаагийн алба хаагчийн баталгаа гэдэг нь алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхдээ улс төр, хууль зүйн, нийгэм, эдийн засгийн хувьд бие даасан байдлаа ханган ажиллах боломжийг бүрдүүлэхтэй холбоотой үндсэн нөхцөлийг хэлнэ¹ гэж тодорхойлжээ.

Судлаач Н.Лхагвасайхан нь цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг судалсан бөгөөд хүний эрх эрх чөлөөг хангахтай холбон авч судалсан байна. Тэрээр хүний эрх, эрх чөлөөг амьдралд тууштай хэрэгжүүлэх, сахин хамгаалах нөхцөл, хэлбэр, аргын нийлбэрийг баталгаатай холбон тайлбарласан. ... Нийгмийн баталгаа гэдэг нь хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх

нийгмийн боломж нөхцөлийг бүрдүүлэхийг хэлнэ гэж тайлбарласан².

Цагдаагийн албаны тухай хуулийн 8 дугаар бүлэг буюу “Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал” гэсэн бүлэгт цагдаагийн алба хаагчийн эрх, үүргийг 68 дугаар зүйлд, харин хориглох зүйлийг 69 дүгээр зүйлд, баталгааг 83-87 дугаар зүйлд тус тус заажээ.

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуульд алба хаагчийн баталгааг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Улс төрийн баталгаа;
2. Хууль зүйн баталгаа;
3. Нийгмийн баталгаа;
4. Бусад баталгаа гэж ангилан

зохицуулжээ.

Эдгээр баталгаанууд нь хоорондоо ялгаатай бөгөөд нийгмийн баталгаа нь цагдаагийн алба хаагч ажил үүргээ хэвийн гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангаж, ажлын бүтээмжид шууд нөлөөлөх, нийгэмд тулгамдаж буй асуудалд бэлэн байх, даван туулах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн байдаг. Харин эдийн засгийн баталгаа нь цагдаагийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд хэнээс ч хараат бус, авлига, хээл хахуульд өртөхгүй байх нөхцөл бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой байна. Тиймээс цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг үр дүнтэй тодорхойлж өгснөөр байгууллагын нэр хүнд, нийгэмд эзлэх байр суурь болон ажлын бүтээмжид эерэг нөлөө үзүүлэхээр байна.

¹ Долгорсүрэн, Ж. Булган. Д. Цагдаагийн эрх зүйн курс. Уб., 2014 он.

² Лхагвасайхан, Н. Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг хангах эрх зүйн

зохицуулалтыг боловсронгуй болгох арга зам. УБ., 2011 он.

Хоёр. Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг төрийн тусгай алба хаагчийн нийгмийн баталгаатай харьцуулан судлах нь.

Монгол Улсын Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн II бүлгийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй”¹ гэж заасан. Энэхүү зохицуулалт нь Монгол Улсын иргэн, төрийн алба хаагчид тодорхой зарим төрлийн дэмжлэг авах, үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлэх гол эрх зүйн үндэс нь болно.

Төрийн албаны тухай хуульд “төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, нийгмийн баталгаа” гэсэн нэртэйгээр байгууллагын дэмжлэгийн гол зохицуулалтыг тусгасан бөгөөд арван дөрөвдүгээр бүлэгт “төрийн албан хаагчийн цалин хөлс”, “төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох”, арван тавдугаар бүлэгт “төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр”, арван зургаадугаар бүлэгт “төрийн албан хаагчид олгох тусламж”, арван долдугаар бүлэгт “төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа”, арван наймдугаар бүлэг “төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгаа”,

арван есдүгээр бүлэгт “дүрэмт хувцас хэрэглэх эрх бүхий төрийн албан хаагч” гэсэн агуулгыг тусгаж, зохицуулжээ.

Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг төрийн тусгай бусад алба хаагчийн баталгаатай харьцуулан авч үзэхэд байгууллагын чиг үүрэг, хийж буй ажлын онцлог, ажлын ачаалал зэргээс шалтгаалан өөр өөр байдлаар тусгагдсан байна.

Төрийн тусгай алба хаагчийн нийгмийн баталгааг “Цагдаагийн албаны тухай хууль”, “Монгол Улсын хилийн тухай хууль”, “Гамшгаас хамгаалах тухай хууль”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тухай хууль”, “Прокурорын тухай хууль”, “Авилгийн эсрэг хууль”, “Тагнуулын байгууллагын тухай хууль”-д өөр өөрийн байгууллагын онцлогт нийцүүлэн тусгасныг харьцуулан авч үзье.

Энэхүү сэдвийн хүрээнд төрийн тусгай алба хаагчийн нийгмийн баталгааг “Цагдаагийн албаны тухай хууль”, “Монгол Улсын хилийн тухай хууль”, “Гамшгаас хамгаалах тухай хууль”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тухай хууль”, “Авилгийн эсрэг хууль”, “Тагнуулын байгууллагын тухай хууль”-д өөр өөрийн байгууллагын онцлогт нийцүүлэн тусгасныг харьцуулан авч үзье.

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ, 2000, 95 дахь тал.

Хүснэгт 1. Хуулийн харьцуулалт

Баталгааны төрөл	ЦАТХ ¹	МУХТХ ²	ШШТХ ³	ШШГТХ ⁴	ГХТХ ⁵	ТТХТХ ⁶	АЭХ ⁷
Улс төрийн баталгаа	+		+	+			+
Хууль зүйн баталгаа	+		+	+			+
Нийгмийн баталгаа	+		+	+			+
Эдийн засгийн баталгаа	+		+	+			+
Аюулгүй байдлын баталгаа						+	
Албан үүргээ гүйцэтгэх баталгаа					+	+	
Иргэний эрх зүйн баталгаа		+					
Бусад баталгаа	+		+	+			+

Дээрх хүснэгтээс харахад төрийн тусгай алба хаагчдын баталгааг салбарын хуулиудад олон янзаар нэрлэсэн байх бөгөөд цагдаагийн алба хаагч нь улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засгийн болон бусад баталгаагаар хангагдахаар заасан байна. Харин бусад алба хаагч тухайлбал, шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчийн хувьд аюулгүй байдлын баталгаа, онцгой байдал, төрийн тусгай хамгаалалтын алба хаагчдад албан үүргээ гүйцэтгэх баталгаа, хилчин алба хаагчийн хувьд иргэний

эрх зүйн баталгаа гэсэн нэршилтэйгээр хэрэглэжээ.

Төрийн тусгай алба хаагчийн нийгмийн баталгааг дараах асуудлын хүрээнд хууль тогтоомжид хуульчлан зохицуулсан байна. Үүнд:

1. Төрийн алба хаагчийн цалин хөлс, түүнд олгох нөхөх төлбөр, тусламж олгох буюу эдийн засгийн баталгааг бий болгохтой холбоотой зохицуулалт (ТАТХ-ийн 57-60 дугаар зүйл);

2. Ажиллах орчин, албаны унаа хэрэглэх, ээлжийн амралт эдлэхтэй холбоотой баталгаа (ТАТХ-ийн 61 дүгээр зүйл);

¹ Цагдаагийн албаны тухай хууль. (2017) www.legalinfo.mn

² Монгол Улсын хилийн тухай хууль. (2016) www.legalinfo.mn

³ Шүүх шинжилгээний тухай хууль. (2022) www.legalinfo.mn

⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. (2017) www.legalinfo.mn

⁵ Гамшгаас хамгаалах тухай хууль. (2017) www.legalinfo.mn

⁶ Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль. (1995) www.legalinfo.mn

⁷ Авлигын эсрэг хууль. (2006) www.legalinfo.mn

3. Нийгмийн хэрэгцээг хангахад чиглэсэн баталгаа гаргахтай холбоотой зохицуулалт (орон байраар хангагдахад дэмжлэг үзүүлэх, орон байраар хангагдах, тэтгэвэр тэтгэмж, суралцах боломжоор хангагдах);

4. Бусад баталгаа (албан үүргээ биелүүлэхтэй холбоотой учирсан хохирлыг барагдуулах, хууль бусаар халагдахгүй, орон тоо цомхотгол болон цөөрсөн тохиолдолд тодорхой хэлбэрийн дэмжлэг үзүүлэх г.м)

Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгаатай холбоотой зарим хуулийн зохицуулалтыг төрийн тусгай бусад алба хаагчийн нийгмийн баталгаатай харьцуулан авч үзье. Жишээлбэл, дараах хүснэгтээр цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь нас алдсан ямар баталгаагаар хангагдсаныг харьцуулан үзье.

Хүснэгт 2. Алба хаагчид амь насаараа хохирсон тохиолдолд олгох тэтгэмжийн эрх зүйн зохицуулалт

Албан үүргээ биелүүлж яваад амь насаа алдсан үед			
Цагдаагийн албаны тухай хууль.	Монгол Улсын хилийн тухай хууль	Гамшгаас хамгаалах тухай хууль	Шүүх шинжилгээний тухай хууль
86.1. Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно.	39.2 Иргэн улсын хилд албан үүрэг гүйцэтгэх үедээ гэмт халдлагын улмаас амь насаа алдвал түүний гэр бүлд энэ хуулийн 39.8-д заасан цалингийн дунджаар тооцсон таван жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно	49.3. Онцгой байдлын байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно	71.6. Шинжилгээний байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно.

Дээрх хүснэгтэд Монгол Улсын хилийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, шүүх шинжилгээний тухай хуульд зааснаар алба хаагчдыг амь насаа алдсан үед үзүүлэх нөхөн төлбөрийг

харьцуулан үзлээ. Харин хүснэгт №03-д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд заасныг харьцуулан үзье.

Албан үүргээ биелүүлж яваад амь насаа алдсан үед		
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тухай хууль	Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль	Авлигын эсрэг хууль
286.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно.	16.1. Албан үүргээ биелүүлэх үед нь төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид учирсан хохирлыг төр хариуцна.	30.3. Авлигатай тэмцэх газрын албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа амь насаа алдсан буюу албан үүрэгтэй нь холбогдуулан амь насыг нь хохироосон бол түүний ар гэрт 5 жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

Дээрх харьцуулалтаас харахад цагдаагийн алба хаагч үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгохоор заасан. Харин Онцгой байдлын болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Прокурорын байгууллагын алба

хаагч амь насаа алдсан бол 10 жилийн цалинтай тэнцэх хэмжээний цалин, Хил хамгаалах байгууллага, Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн гэр бүлд 5 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгохоор тус тус заасан байна. Энэ нь тухайн алба хаагчийн сарын цалингийн хэмжээнээс хамаарч өөр өөр байх нь харагдаж байна.

	Төрийн тусгай алба хаагч	Цалин	Бодолт
1	Цагдаагийн алба хаагч (Мөрдөгч)	641363 ¹	641363*120 сар=76,963,560
2	Прокурор (дүүргийн)	1 820 000 ²	1820000*120сар =218,400,000
3	Авлигатай тэмцэх байгууллагын ажилтан	2 533 104 ³	2533104* 120сар 151,986,240

Хүснэгт 3. Төрийн тусгай алба хаагчийн цалингийн хэмжээ.

Хүснэгтээс харахад авлигатай 3-4 дахин их байгаа бөгөөд 5 жилээр тэмцэх алба хаагчийн цалин үржүүлсэн ч их хэвээр гарч байна. цагдаагийн алба хаагчийн цалингаас Өөрөөр хэлбэл, 10 жилийн үндсэн

¹ Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт. Төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээ.

² Монгол Улсын Их хурлын 2016 оны 65 дугаар тогтоол. Монгол улсын прокурорын байгууллагын прокурорын албан тушаалын цалингийн хэмжээ

³ Монгол Улсын Их хурлын 2021 оны 85 дугаар тогтоолын хавсралт
Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ

цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг авах хэдий ч цалингийн хэмжээнээс хамаарч олгогдох тэтгэмж бага байна.

Мөн хүснэгтээр харьцуулж буй төрийн тусгай алба хаагчид нь цагдаагийн алба хаагчидтай нэгэн адил гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлдэг хэдий ч бага цалинтай, илүү өндөр эрсдэл бүхий ажилд нүүр тулан ажиллаж байна. Цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь ард иргэдийнхээ амар тайван амьдралын төлөө өөрийн сэтгэл зүрхээ зориулан, албан үүргээ гүйцэтгэж яваад баатарлагаар алтан амиа өргөсөн 39, төр, ард түмнийхээ

амар тайван амьдралын төлөө өөрийн амь насаа зориулан 71 алба хаагч¹ нийт 110 алба хаагч байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2-т “Цагдаагийн алба хаагчийн албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно” гэж заасныг бусад алба хаагчидтай харьцуулан авч үзье.

Хүснэгт 4. Ажилласан жилийн нэмэгдэл

№	Төрийн тусгай алба хаагч	Ажилласан жилийн нэмэгдэл
1	Цагдаагийн алба хаагч	Цагдаагийн алба хаагчийн албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно.
2	Прокурор (дүүргийн)	Ажилласан жилээр
3	Авлигатай тэмцэх байгууллагын ажилтан	Ажилласан жилээр
4	Онцгой байдлын алба хаагч	50.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн алба хаасан хугацааг тооцохдоо алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцно /дүйцүүлэн тооцох хугацааг 1999 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцно/.
5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн баривчлах байр, цагдан хорих төв, цагдан хорих байр, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хаалттай хорих ангид 1 жил ажилласан хугацааг 1 жил 3 сар, нээлттэй хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага болон харьяа бусад байгууллагад 1 жил ажилласан хугацааг 1 жил 2 сар ажилласанд тооцно.

¹ “Бид мартахгүй” хөшөөний нээлт, цэцэг өргөх хүндэтгэлийн арга хэмжээ.

<https://www.montsame.mn/en/read/270019>.
2023.12.25

Хүснэгтээс харахад цагдаа, шүүхийн шийдвэр, онцгой байдлын алба хаагчдын ажилсан жилийн нэмэгдлийг 1.2-1.4 сар хүртэл хугацаагаар нэмэгдүүлж тооцохоор холбогдох хуулиудад тусгасан байна. Эндээс онцгой байдлын байгууллагын бүх алба хаагчид зургаан сар тутмыг найман сард тооцож байгаа нь захиргааны болон бусад туслах чиг үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад давуу талыг болгож байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.3.1-д цагдаагийн алба хаагчийн эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой зохицуулалтыг нийгмийн баталгааны хэсэгт тусгасан байна. Энэхүү зохицуулалтыг төрийн тусгай бусад алба хаагчийн баталгаатай харьцуулан үзэхэд:

1. Цагдаагийн алба хаагч ажил үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэндээр хохирсон тохиолдолд олгох нөхөн олговор чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь бусад төрийн тусгай алба хаагчийн эрүүл мэндийн баталгаатай харьцуулан үзэхэд адилхан зохицуулагдсан байна.

2. Онцгой байдлын байгууллага алба хаагчийн эрүүл мэндийн баталгааг “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 50 дугаар зүйлийн 50.6-д Онцгой байдлын байгууллагын алба хаагчид амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэвэл

мөнгөн урамшуулал олгох, 50.7.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд заавал даатгуулах бөгөөд зардлыг төр хариуцна гэж заасан¹ нь давуу зохицуулалтыг бий болгожээ.

Цагдаагийн алба хаагч гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд гал түймэр, гоц халдварт өвчин, байгалийн гамшиг, зам тээврийн осол, гэнэтийн болон, үйлдвэрлэлийн осол, хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагаанд хяналт тавих, хуяглан хүргэх зэрэг бүхий л төрийн чиг үүрэг бүхий байгууллагын ажил үүрэгтэй уялдаа холбоотой, хамтран ажилладаг. Мөн ажил үүргийн хувьд бусад төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудаас ажлын ачаалал, амь насаараа хохирох эрсдэл өндөр, амь насны болон эрүүл мэндийн баталгаа бусад байгууллагын алба хаагчдаас хангалтгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх эрхийг иргэнийхээ өмнө хариуцна² гэж заасанчлан алба хаагчийн эрх ашиг ямагт нэгдүгээрт

¹ Гамшгаас хамгаалах тухай хууль 2017 он. [//legalinfo.mn/mn/detail/12458](http://legalinfo.mn/mn/detail/12458). 2024.02.25

² Монгол улсын үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг. УБ. 1992 он.

байх нь зайлшгүй юм. Тиймээс цагдаагийн байгууллагын алба хаагч бүрийг амь насны болон эрүүл мэндийн эрсдэлийн даатгалд бүрэн хамруулах явдал нэн тэргүүнд тавигдах явдал юм.

Дүгнэлт

Цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг өдөр тутамдаа хэрэгжүүлж, Цагдаагийн албаны тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээж, албаны өндөржүүлсэн бэлэн байдалд түргэн, шуурхай ажилладаг онцлог бүхий субъект юм. Энэхүү чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэхэд цагдаагийн байгууллага алба хаагчдаа зайлшгүй дэмжлэг үзүүлэх шаардлагатай бөгөөд энэ нь эдийн засаг, нийгмийн баталгаагаар илэрч байна. Өөрөөр хэлбэл, байгууллагын дэмжлэг гэсэн ойлголтыг манай улсын цагдаагийн байгууллагад алба хаагчийн баталгаатай холбон тайлбарлаж болохоор байна. Энэ нь цагдаагийн байгууллагын дэмжлэг нь эдийн засгийн хүрээнд үзүүлэх дэмжлэг, нийгмийн хүрээнд үзүүлэх дэмжлэг, хууль зүйн дэмжлэг байна гэж тодорхойлж болохоор байна.

Төрийн албаны тухай хуульд заасан баталгааг салбар хуулиудад өөр өөр хуульчилж, нэгдсэн бодлого, ижилтгэн үзэх зарчмаар бус нөхцөлөөр хангах зохицуулалтыг тусгасан байна. Тухайлбал, Шүүх шинжилгээний тухай хуулийн 73 дугаар зүйлд шинжилгээний

байгууллагын алба хаагчийн аюулгүй

байдлын баталгааны талаар тухайлан заасан. Харин Хилийн тухай хуульд иргэний эрх зүйн баталгаа гэсэн нэр томьёог хэрэглэсэн байна.

Энэ нь төрийн албан хаагчдын ажил үүргийн онцлог байдлыг харгалзан нийгмийн баталгааг тухайлан зохицуулсан хэдий ч суурь зохицуулалтаа харгалзаж үзэлгүй салбарын хууль бүрт харилцан уялдаагүйгээр нийгмийн баталгааг хангах зохицуулалт хийж байгаа нь зохистой биш юм.

Цагдаагийн алба хаагч байгууллагын дэмжлэгийг хүлээж байгаа тохиолдолд байгууллагынхаа төлөөх үр дүн нь үргэлж эерэг байх бөгөөд байгууллага зорилгодоо хүрэхэд тусалдаг. Дүгнэж хэлэхэд ажилчдад үнэ цэнийг өгөх нь эргээд байгууллага өөртөө үнэ цэнийг өгч байна гэж тодорхойлж болно.

Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгаа төрийн тусгай бусад алба хаагчдын нийгмийн баталгаанаас доогуур үзүүлэлтэй байна. Энэ нь алба хаагчийн цалингийн хэмжээ, хөнгөлөлт, дэмжлэгийн хэмжээ, албан тушаалын зэрэглэлээр тодорхойлогдож байна. Энэ нь цаашлаад ирээдүйд тэтгэвэр, тэтгэмжид шууд нөлөөлөхөөр байна. Өөрөөр хэлбэл, цагдаагийн алба хаагчидтай адил чиг үүрэг гүйцэтгэж буй төрийн тусгай зарим алба хаагчдын цалингаас 3-5 дахин бага байгаа нь цагдаагийн алба хаагчийн баталгаа хангагдаагүй, байгууллагын

дэмжлэг муу гэж дүгнэж болохоор байна.

Санал

1. Байгууллагын дэмжлэгийн онол, нийгмийн солилцооны онолыг цаашид дэлгэрүүлэн судалж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

2. Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг нарийвчлан судалж, сайжруулах. Өөрөөр хэлбэл, цагдаагийн алба хаагчийн цалинг нэмэгдүүлэх, аймгийн төвөөс бусад сумдад ажиллаж буй алба хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах, орон сууц, хоол хүнсний хангамжийг бий болгох, цалингийн тодорхой хувь бий болгох нь зүйтэй юм.

3. Цагдаагийн байгууллагын удирдлагын зүгээс ажлын үр дүнгээрээ хангалтгүй ажилласан алба хаагчдын цалинг үр дүнгээс нь хасдаг асуудлыг байхгүй болгож өөр арга замаар хариуцлага тооцдог аргачлалыг бий болгох.

4. Сумдад ажиллаж буй алба хаагчдын гэр бүлийг гишүүний нийгмийн даатгалыг төлөх г.м.

Эх сурвалжийн жагсаалт

-Монгол Улсын Үндсэн хууль. УБ.,1992 он.

-Төрийн албаны тухай хууль. УБ.,2002, 2017 он.

-Цагдаагийн албаны тухай хууль. УБ., 2017 он.

-Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль УБ., 2004 он

-Гамшгаас хамгаалах тухай хууль. УБ., 2017 он

-Хилийн тухай хууль. УБ., 2016 он.

-Хөдөлмөрийн тухай хууль. УБ.,2021 он.

-Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль. УБ., 1995 он.

-Шүүх шинжилгээний тухай хууль. УБ., 2022 он.

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017 он.

-Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль. УБ., 2004 он.

-Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр. ЗГ-ын 2020 оны 141 тогтоол.

Хоёр. Ном, сурах бичиг, нэг сэдэвт бүтээл

-Долгорсүрэн, Ж. Булган, Д, Монгол Улсын цагдаагийн эрх зүйн курс. УБ, 2014 он.

-Монгол Улсын цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, М.Батаев, УБ, 2006 он

-Монгол Улсын цагдаагийн эрх зүй, Д.Таванжин, УБ, 2006 он

-Н.Лхагвасайхан. Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг хангах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга зам, УБ, 2011 он.

-Lakey, B. and S. Cohen, 2000. Social support theory and measurement (pp. 29-52). In Social Support Measurement and Intervention: A guide for Health and Social Scientists. (Eds. Cohen, Underwood and Gottlieb).

-Eisenberger, R., Cummings, J., Armeli, S., & Lynch, P. (1997). Perceived organizational support,

discretionary treatment, and job satisfaction. *Journal of Applied Psychology*, 81(5), 812-820. doi: 10.1037//0021-9010.82.5.812

-Eisenberger, R., Huntington, R., Hutchison, S., & Sowa, D. (1986). Perceived organizational support.

Journal of Applied Psychology, 71(3), 500–507.

-Rhoades, L., & Eisenberger, R. (2002). Perceived organizational support: A review of literature. *Journal of Applied Psychology*, 87(4), 698–714. doi: 10.1.1.561.8147